

ЭЦГИЙНХЭЭ ТУХАЙ ӨГҮҮЛЭХҮЙ

Н.Осоржамаа

Миний аав Дагвын Нямсүрэн 1906 оны гал морин жил Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин вангийн хушуу одоогийн Булган аймгийн Орхон сумын (хуучин Халиун сум) нутаг Нарийн могой гэдэг газар ард Дагвын ууган хүү болж мэндэлжээ.

Вангийн хүрээ, Их хүрээний хооронд явж ном үзэж, улаан сахиусын шидийг хүртэж Чойжин болсон аж. Ардын Хатанбаатар Магсаржавыг таалал төгссөний дараа түүнийг Булганы хүрээнд Чойжингоор залах гэж байсан гэдэг. (Хатанбаатар ван Чойжин буудаг байсан, түүнийг залгамжлагч гэж яригдаж байсан. Ред)

Миний аав Нямсүрэнгийн талаар хожим нь дүү Маналын Лхамсүрэн: манай Өндөө (Манай аавыг өөрийн ах дүүс нутаг усныхан нь Өндөө гэж авгайлан дууддаг байсан) их сайн Чойжин хүн байлаа, миний охин аавыгаа мэдэх үү гэж байгаад ийнхүү ярьж өгсөн юм. Манай Өндөө сахиусаа залахаараа их аймаар догшин сүртэй болдог байлаа. Өндөөг сахиусаа залахад нь ах дүүс нутаг усныхан маань түүний сахиусны авралд багтахар цугларна. Нэг удаагийн сахиусаа залахад нь манай нутгийн архи ууж, агсан тавьчихдаг, тамхи ч баагиулдаг, яггүй хөдөлгөөний эр ирж таарсан юм, гэтэл Өндөө маань сахиусаа залж байснаа гэрт цугларсан олон хүний ард сууж байсан нөгөө хүнийг аравын битонтой ус өргөж байгаа юм шиг далан дээрээс нь гараараа шүүрч авч, урдаа дөрвөн хөллүүлж тавиад, хар архичин, улаан тамхины эзэн гээд л ар нуруу руу нь сэлмээрээ урагшаа нэвт гартал сүлбэхэд хонины өвчүү хадаж байгаа юм шиг пүр пүр хийж дуугараад, "сэлэм нь сайн төө илүү нэвт гарч харагдсан, тэгэхэд бид чинь айж, нүдээ аньж залбиран, тонгойгоод л одоо ингээд үхчихлээ гэж бодон хөдөлж чиг чадахгүй жаахан байж байгаад хартал нөгөө хүн маань зүв зүгээр сууж байсан. Өндөө маань ч сахиусаа залаад дууслаа, тэгээд тэндээсээ гарч нөгөө хүнээсээ зүгээр үү, яаж байна гэж асуугаад нөгөө гэртээ оруулж, хувцасыг нь тайлаад үзэхэд цамц нь цоорсон бие нь ар өвөр хоёрт цагаан зураас шиг юм гарсанаас өөр шарх сорви гарч, цус гоожсон юм байгаагүй юм. Яах аргагүй л пүр хийж дуугараад нэвт гарч байсан гэж тэнд байсан хүмүүс гайхацгааж байж билээ. Тэгээд л тэр хүн маань дахиж архи уухаа байчихсан гэж эгч маань надад хуучилсан юм.

Эгчийнхээ ярьсан зүйлийг би ээжээсээ миний аав үнэхээрийн тийм хүн байсан юм уу гэсэн чинь ээж минь тиймээ үнэн, ээж нь охиндоо гай болно гэж бодоод хэлдэггүй байсан юмаа, одоо ч бурхан номоо шүтдэг болсон болохоор гайгүй байгаа даа гээд миний ээж Даваажав хожим нь дээр өгүүлсэн зүйлийг үнэн гээд, мөн хаанахын хүн байсан юм бэ? лав л манай нутгийн хүн байгаагүй Шүхэр бөө гэж хүн манай нутгаар явдаг байлаа. Тэр Шүхэр бөө хүнээр манай нутгийн Жамъянхүү гэдэг хүнд хүн хараал хийлгээд, тэр бөөгийн холбого нь тэр Жамъянхүүгийн гуяны маханд орчихлоо гэж хүн ирж, миний аавыг аргалж өгөөч гээд залж аваачсан чинь аав маань бүсэндээ зүүж явсан эвхдэг хутгаа гаргаж ирж юм уншиж хутга руугаа үлээчихээд, гуяны махыг нь зүсч, нөгөө бөөгийн холбогыг нь аваад гэртээ авчиран, цаасан дээр юм бичиж, гурвалжин хар тэг гадуур нь зурж, нөгөө холбогоо тавьж, дээрээс нь хонх хөмрөн орхисон. Дараа нь Шүхэр бөө ирээд миний хоолыг өгөөч гэж хоёр ч удаа гуйхад нь өгөөгүй, буцаагаад гурав дахь удаагаа ирж хадаг барин сөхөрч мөргөөд байхаар нь хэдэн голын минь ах дүүсийн махыг дахиж идэхгүй байж чадвал өгнө гэж ам тангарагийг нь авч хадгийг нь аваад холбогыг өгөөд явуулсан. Түүнээс хойш тэр бөө манай нутгаар дахиж үзэгдээгүй алга болсон гэж ярьсан билээ.

Мөн манай нутгийн хавчиг Дорж гэдэг хүн айлын найран дээр аавд маань агсам тавьж, чамайг хараал хийлгэж ална гэсэн юм гэнэлээ. Юунаас болсон юм бүү мэд, тэгээд Халиун сум (Эдүгээ Орхон сумын Халиун баг. Ред) орж, ноосоо тушаах гэж яваад Арбулаг гэдэг газарт зусч байсан паадага хэмээх Жамъян гуайнд хонох болжээ. Гэтэл гэрийн эзэн Жамъян гуай орой адуугаа Хөхдаваа гэдгээр давуулж, Мухдагийн эхэнд тогтоогоод ирэхдээ хавчиг Дорж орой удганыд ирж байсан Хорол удганы тал хэнгэрэг дуугараад л байна, хэнд хараал хийлгэж байгаа юм бол доо гэж гэнэ. Гэтэл манай аав инээд алдаад, аа надад хараал хийлгэж байгаа юм аа гээд ажигчгүй сууж байсан гэнэ. Тэгсэн тэр айлынхан нь: за, өнөө шөнө Нямсүрэн манайд үхэж бид хэрэгт орох болох нь яана даа гэж айж байвч хөөгөөд явуулах хэцүү аргагүйдэж хонуулсан байна. Айлынхан шөнө айгаад чимээ гарах нь уу гээд түгшиж л хонож, харин аав маань өглөө юу ч бололгүй босч, цай уучихаад ноосоо тушаахаар ачаа хөсөгтэй дүү нарынхаа араас яваад өгч гэнэ. Тэгтэл үдээс хойхно нөгөө Жамъян гуайнхан хонио хотлуулчихсан сааж байтал манай аав нилээд их согтуу хойт талын замаар нь хоёр ханцуйгаа сугалдаргалаад унжуулчихсан, хоёр тийшээ найгахад нь ханцуйны нь үзүүр газар шүргэж давхин,

Хөх даваагаар даваад явчихаж Жамъян гуайнхан ч Нямсүрэн урьд шөнө манайд үхэлгүй хоносон, одоо л сүйд болох нь гэж ярьцгааж байж. Гэтэл нөгөө Хорол удганыд давхиж очиж үүдэнд нь тулж зогсоод, морио сул орхин гэрт нь орж, Хорол удганд хандан, чи хэдэн голынхоо ах дүүсийн махыг нь идэж цусыг нь сорж ханаагүй юу чи, яасан их хүнд хараал хийдэг хүн бэ, чи долоон сэтэрхий тогоогий чинь хага цохино доо чамайг гэж агсам тавиад Хорол удганы шүтдэг бурханыг нь авч, чи юугаа үзэж, юугаа хардаг бурхан бэ гээд тулганд асч байсан гал руу нь хийчихсэн гэдэг. Тэгтэл удган, ээ, элээ халаг минь гээд галын хайчаар бурханаа хавчаад гал дотроос автал Хорол удганы нөхөр Дэлгэр гуай гэдэг өвгөн хонинд явж ирээд цайгаа ууж суусанаа үнээн, үнэн Нямсүрэн минь өчигдөр орой хавчиг Дорж ирж вандан хадаг 50 төгрөг өгч, чамд хараал хийлгэсэн үнэн шүү, үнэн намайг наадах чинь шөлний минь хэдээс салгах гэж байгаа юм гэж байсан юм гэнэ лээ гэж ээж минь надад ярьж байсан юм. Уул нь манай аав архи тэгтлээ уудаггүй хүн байсан боловч Хорол удганыг айлгахын тулд л архи уусан хэрэг.

Миний аавын сахиусаа залахдаа зангидсан сэлэм нь өөрийнх нь найз Гун-Аажав гэдэг хүнд байж байгаад, саяхан түүний гэр бүлийн хүн Сосор гэдэг хөгшинд байсан, түүнийг бурхан болоход хаягдсан юм уу эсвэл тэр хүний ах дүү болох улаан Баасан гэдэг хүнд очсон байж магадгүй юм. Төрсөн дүү Дагвын Лхамсүрэн нь манай Өндөө сахиусаа залж байхдаа сэлмээ гараараа хэд шувтрахад сэлэм нь улайсдаг, түүнийгээ хэлээрээ шар хийтэл долоогоод, даавуу зангидаж байгаа юм шиг зангиддаг байлаа гэж ярьж байсан. Миний мэдэхээр аав минь нуруулаг, цэх хүн байсан. Надад дандаа модон сийлбэр тоглоом хийж өгдөг байсан. Гоё гоё сийлбэр морь, хонь, ямаа, арслан, өлзий шувуу зэрэг олон тоглоомууд байсныг дүү нартаа болон айлын хүүхдэд өгөөд, одоо ганц цагаан азарга л үлдсэн юм. Одоо надад хадгалагдаж байгаа. Аавын минь хэрэглэж байсан эд зүйлээс хэцүү хатуу цагт ид шидээр багасгаж хэрэглэж байсан сэлэм (таван өнгийн хадаг уяатай), ишиндээ очиртой жижиг хувилбар очир арилд бурхан, Жадамба, Алтангэрэл, Сундуйн жүд модон шоголтой судар нь хадгалагдаж буй. Бусад ном судар, бурхан хувцас хэрэглэл зэргийг та нар шүтэж чадахгүй, тэгээд ч та нарт гай болно гээд уул хаданд нуучихсан юм гэнэ лээ.

Аав маань 1940 онд миний ээж Даваажавтай гэр бүл болж таван хүүхэдтэй болсон. Халиун сумын "Туяа" нэгдлийг анх байгуулагдахад аав ууган гишүүнээр элсэж, малаа нийгэмчилж, мужаанаар ажиллаж байгаад 1956 онд бурхан болсон

юм. Миний аав Нямсүрэн их номхон дөлгөөн сайхан зантай огт уурладаггүй, хүн уурлавал бүтэн сар уурлахгүй бол ямар уурласан болхов дээ гэж суудаг хүн байсан гэж ээж минь хэлдэг байлаа.

Өвөг эцэг, эмгэн эх нар маань ч уужуу тайван, удмын сайхан хүмүүс байсан бөгөөд аавын дүү нар, бэр хүргэнүүд нь хүртэл миний ээж Даваажавыг бүгдээрээ Даваа ижий хэмээн хүндэтгэж, авгайлан дууддаг байлаа. Аав минь айлын 12 хүүхдийн том нь байсан бөгөөд отгон дүү. Дагвын Лхамсүрэн нь одоо Булган аймгийн Орхон суманд 83 настай амьд сэрүүн, тэнхлүүн амьдарч байна. Миний өвөг эцэг Дагва олон хүүхэдтэй байсан учир өвлийн хүйтэнд айлын хүүхдүүд ирэхээр дааруулахгүй аятай тохьтой тоглуулахын тулд хоёр авдараа гадаа гаргаж тавьчихаад, гэртээ бужигнуулдаг байсан юм гэнэ лээ. Миний аав Нямсүрэн Нарийн могой, Зүрхийн могой, Хялганат, Бичигт, Хужирт зэрэг Орхон голын хойт урд талаар амьдарч байсан бөгөөд голын хүрмэн хаднуудаар нүдний талим маань зэргийг сийлдэг байсан нь одоо хүртэл байдаг юм.

Нямсүрэнгийн охин Осоржамаа би багадаа 1971 онд хонинд явж байхдаа Ар шангай буюу Багашангайн даваанд нэг хадан дээр морь сийлсэн нь одоо морьт хөтөл нэртэй болсон юм. Энэ үед аавыгаа тийм хаданд сийлбэр хийдэг хүн байсан гэж мэддэггүй, зүгээр л хүүхдийн зангаараа л морины дүрс гаргасан нь одоо манай нутгийнхан болон тэр даваагаар давахдаа хүмүүс их бэлэгшээж их очдог юм билээ. Эдгээр чулууны бичиг дүрсүүд нь одоогийн Булган аймгийн Орхон сумын Халиун багийн нутгаар тааралддаг болно.

Өөрийн эцэг Дагвын Нямсүрэнгийн амьдралын түүхийг ээж Даваажав болон дүү Лхамсүрэн нараас нь сонссоноороо тодотгон бичсэн болой.